

**Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын
Ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэл /2013-12-03/**

Ажлын хэсгийн 33 дугаар хуралдаан 2013 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 14.30 цагт Нээлттэй нийгэм форумын хурлын танхимд зохиогдов.

Ажлын хэсгийн хуралдаанд Уул уурхайн яамны стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ч. Отгочулуу, мөн яамны төсөл хариуцсан мэргэжилтэн Зууннаст, Засгийн газрын ахлах референт Э.Сумъяа, , Ашигт малтмалын газрын тасгийн дарга н.Бямбадагва, мөн газрын мэргэжилтэн Д.Мөнхсайхан Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газрын мэргэжилтэн Г.Зулай, Татварын ерөнхий газрын дэд дарга А.Энхболд, татварын байцаагч Д.Энхтуяа, Газрын тосны газрын мэргэжилтэн Ш.Маргад, Сэлэнгэ аймгийн Хөгжлийн бодлогын газрын мэргэжилтэн Б.Мөнхбат, Монголын Уул уурхайн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал Н.Алгаа, Хил хязгааргүй алхам ТББ-ын тэргүүн Н.Баярсайхан, МБОИЗ-ийн удирдах зөвлөлийн гишүүн Б.Батболд, МБОИЗ-ийн гишүүн Гомбожав, Ил тод сан ТББ-ын гүйцэтгэх захирал Д.Цэрэнжав, Хөвсгөл далайн эзэд сангийн тэргүүн Б.Баярмаа, Хариуцлагатай уул уурхай ТББ-ын тэргүүн Долгормаа, Нээлттэй нийгэм форумын уул уурхайн менежер Н.Дорждарь, Ариун суврага хөдөлгөөний тэргүүн Г.Чагнаадорж, Хүний эрх хөгжлийн төвийн ажилтан Н.Байгалмаа, Бороо гоулд компанийн татварын нягтлан бодогч Н.Болормаа, Багануур ХК-ны Санхүүгийн хэлтсийн дарга н.Очирлхам, Эрдэнэмонгол ХХК-ийн орон нутгийн харилцаа хариуцсан менежер П.Эрдэнэбилэг, Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга, ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон нар оролцов. Хуралд ажлын хэсгийн 33 гишүүнээс 22 гишүүн оролцож ирц 67 хувьтай байв.

Мөн хуралдаанд Их Британийн Стефенс Moore компанийн зөвлөх Радихууле, Монгол улсын Далайван аудит ХХК-ны захирал Б.Жигдэн болон аудитын ажлын баг, Энержи Ресурс компанийн олон нийттэй харилцах албаны дарга н.Сугармаа, ТАН эвслийн захиргааны ажилтан Б.Уранчимэг, ажлын албаны харилцааны мэргэжилтэн Б.Дэлгэрмаа, санхүүгийн ажилтан А.Отгонтунгалаг нар оролцов.

Хурлын ирцийг ажлын хэсгийн нарийн бичгийн дарга, ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон танилцуулав. Ахлах зөвлөх Гансүхийн даалгавраар Засгийн ахлах референт Э.Сумъяа өнөөдрийн хурлыг удирдан чиглүүлнэ. Ирц хангалттай, 33 гишүүнээс 4 хүндэтгэх шалтгаантай, 22 гишүүн иржээ.

Э.Сумъяа: Та бүхэнд хуралдаа идэвхтэй хүрэлцэн ирсэнд талархлаа илэрхийлье. Хурлын материал болон хөтөлбөр, дотоод журмыг урьдчилан тараасан тул эхэлж хэлэлцэе. Саналтай хүн байна уу. Ямар нэг саналгүй байх тул батлая. Хөтөлбөрийн дагуу нэгдүгээр асуудлаа хэлэлцэе. ОҮИТБС-ийн 2012 оны урьдчилсан нэгтгэл тайлангийн мэдээллийг тус консерциумын зөвлөх н.Радихууле танилцуулна.

I. ХЭЛЭЛЦСЭН нь: Монгол Улсын ОҮИТБС-ын 2012 оны урьдчилсан нэгтгэл тайлан

н.Радицуул: Та бүхэнтэй дахин уулзаж байгаадаа баяртай байна. ОҮИТБС-ийн 2012 оны тайланг урьдчилсан байдлаар дэлгэрэнгүй танилцуулав. /Танилцуулгыг хавсаргав/

Э.Сумъяа: За дэлгэрэнгүй танилцуулга хийсэнд баярлалаа. Тайлангийн иж бүрдлийн талаар Цолмон мэдээлэл хийнэ. Энэ тайлан нь ажлын хэсгийн хурлаар хэлцэгдээд дараа нь Үндэсний зөвлөлд орох ёстай.

Ш.Цолмон: За баярлалаа. Өнөөдрийн ажлын хэсгийн хурлаар Монголын ОҮИТБС-ын 2012 оны тайланг урьдчилсан байдлаар сонслоо. Түрүүний ажлын хэсгийн хурал ирц бүрдээгүй учраас хойшилсон байгаа. Бид ажлын гэрээг 2013 оны 7 дугаар сард хийсэн. Бидэнд тулгараад байгаа нэг асуудал бол гэрээ оройтож хийгдсэн явдал юм. Учир нь тайлан 6 сард гарч дууссаж байгаа учир гэрээ хийгдэх ажил жил бүр оройтож байгаа нь үнэн юм. Үүнийг манай консерциум ил тод гаргаж тавьсан байна. Энэ тайланг маань үндэсний зөвлөлийн хурлаар батлах ёстай. Үндэсний зөвлөлийн хурлыг ойролцоогоор 2 долоо хоногийн дараа хийхээр ярилцаж байгаа. Үүнээс өмнө гэрээнд тусгасан заавал хийх ёстай хэдэн ажлыг хийх нь зүйтэй байх. Үүнд: хандив тусlamжийн судалгааг хийх, төлбөр орлогыг аймаг, сумаар гаргах, зөрүүг (компанитай холбоотой 24 зөрүү, төрийн байгууллагатай холбоотой 6 зөрүү нийт 30 гаруй) арилгах болон хэрхэн шийдэх талаар зөвлөгөө өгөх гэх мэтийн ажлуудыг 14 хоногийн дотор хийх хэрэгтэй байна. Мөн зөрүүг арилгах талаар ажлын хэсэг ч гэсэн хамтран ажиллах боломжтой гэж үзэж байна. Цаашилбал тайландаа зарим нэг жижиг алдаа, нэг томъёоны зөрүү зэрэг зүйлүүд байна. Үүнийгээ эргэж харна биз. Миний хувьд тайлангийн орчуулга сайн хийгдсэн гэж үзэж байна. Харин мэдээллийн талаар зарим нэг алдаа байна. Тухайлбал, Оюу толгой компани 1,5 тонн алтны нөөцтэй ч гэх юм уу жижиг алдаанууд байна. Үүнийгээ дахин тодруулахын тулд газрын тосны газрын болон ашигт малтмалын газрын холбогдох мэргэжилтэнгүүд болон манай ажлын хэсгийн гишүүдэд хандах боломжтой юм. Энэ удаагийн ажлыг сайн гүйцэтгэсэн гэж үзэж байна. Үүнээс ч илүү сайн гүйцэтгэх боломжтой байсан байх гэж бодож байна. Ажлын багийн хувьд маш том чадварлаг баг ажилласан гэж бодож байна. Бид ажлын хэсгийн хурлаар тайланг хэлэлцсэнээр гэрээний төлбөрийн 80 хувийг өгөх боломжтой болох юм. Дараа нь Үндэсний зөвлөлд танилцуулснаар үлдэх 20 хувийн төлбөр батлагдах юм. Төлбөр мөнгө нь саатах вий гэдэг болгоомжполын үүднээс дээр дурдсан зүйлүүдийг тусгаж өгвөл зүйтэй гэж үзэж байгаа юм.

Э.Сумъяа: Манайх бол 3 талын оролцоотой байдаг. Ингээд та бүхэн тайлангийн талаар асуух зүйл байвал асууж болно. Өнөөдрийн энэ тайлан маань ерөнхийдөө зөвлөмж талруугаа хандсан тайлан болсон гэж үзэж байна. Та бүхэн орон нутагт явахдаа ярьж явдаг, сургалтандаа хэрэглэж болохуйц тайлан болсон байна. Тайлангийн талаар болон тоо баримтын талаар, зөвлөмжийн талаар, агуулгын талаар тавих асуулт байвал тавьж болно. Нэрээ хэлээд албан тушаалаа хэлээд асуултаа тавиараа. Зарим нь гаднын хүмүүс байгаа тул танихгүй байх магадлалтай.

Н.Болормаа (Бороо гоулд компанийн татварын нягтлан бодогч): Манай компани нь зөрүүтэй компаниудад нилээд дээгүүр буюу 192,9 сая төгрөгийн зөрүүтэй гэж оруулсан байна. Би энэ олборлох үйлдвэрлэлийн тайланг З дахь жилдээ гаргаж байгаа. Энэ нь бидний хувьд арай өндөр гарсан байна. Бид Далайван компанийн аудитуудтай хамтран ажилласан. Тэр байтугай манай компанийг хамгийн сайн хамтран ажиллалаа гэж хэлж байсан боловч бидний хувьд энэ зөрүү нь миний ажлын үр дүнд сөргөөр нөлөөлөх юм шиг санагдаж байна. Би компанийнхаа бүх төлсөн татвар хураамжийг төлсөн өдөр тутамд нь баримтаар нь бүртгэж хавдив, өр төлбөр, татвар хураамж гэж ангилаад явдаг миний бүтэн 1 жилийн ажлын үр дүнг баллах тоо юм шиг байна. Миний гаргаж өгсөн тайлан дээр 192,9 сая төгрөг Засгийн газраас тайлангаас илүү дүнтэй харагдаад байдаг. Мөн энэ нь манай байгууллагын санхүүгийн сахилга бат, үйл ажиллагааг ямар хэмжээнд байна гэдгийг харуулах үзүүлэлт юм. Энэ талаар Далайван аудитаас асуумаар байна.

н.Гантулга: Бороо гоулд компанийн татварын хувьд тайлан дээрээ мөнгөн болон мөнгөн бус хандив дээрээгээ бий. Тайлантай татварын мөнгөн бусаар хандивласан мөнгөн бусаар хандивыг тохируулахгүй байдаг юм. Түрүүнд манай зөвлөх танилцуулга дээрээ бас энэ талаар хэлсэн байгаа. Тохируулга нь мөнгөн бус хандив дээрээгээ бий. Мөн энэ нь манай байгууллагын санхүүгийн сахилга бат, үйл ажиллагааг ямар хэмжээнд байна гэдгийг харуулах үзүүлэлт юм.

Н.Болормаа: Хандив тусlamжийн хувьд тайлан дээрээ мөнгөн болон мөнгөн бус гэж оруулж болдоггүй юм уу. Тайлантай татварын мөнгөн бусаар хандивласан мөнгөн бусаар хандивыг тохируулахгүй байдаг юм. Тайлантай татварын мөнгөн бус хандив тусlamжаа тусгаж өгөх ёстой байдаг. Энэ 192,9 сая төгрөгийн зөүүг тайландаа мөнгөн бус гэж оруулж өгөх буюу мөнгөн бус хандив тусlamж дээр тохируулга хийгдээгүй гэдэг тайлбар оруулж өгөхгүй бол миний хувьд гомдолтой байна.

Хамгийн гол нь тайлангийн маягтан дээр сайн дурын мэдээлэлийг заавал тавих хэрэгтэй гэж заасан. Мөнгөн бус хандивыг тохируулахгүй байдаг юм бол бид мөнгөн бус хандивыг тайлагнахгүй байвал зөрүүгүй тайлан гарах юм биш уу.

Э.Сумъяа: Аудитын компани мөнгөн бус хандив дээр тайлбар хийж болохгүй юу. Өөрөөр хэлбэл энэ нь Засгийн газар хүлээж аваагүй ажил гэдэгтэй адил юм. Гурван талууд гэрээгээ хийчихээд Засгийн газарт хүлээлгэж өгөөгүй ажлууд байдаг юм. Тэгэхлээр үүн дээр тайлбар хийж болох юм.

Б.Жигдэн: Би тайлбар хийе. Наадмаа хийсэн засаг дарга наадмын байнд компаниудаас мөнгөн бус хандив авдаг. Тухайлбал, түрүү морины шагналд хятад мотоцикль ч юм уу. Гэхдээ тэд үүнийгээ бид төсвөөс гарах мөнгийг хэмнэж, ард түмнийхээ төлөө сайн сайхан юм хийлээ гэж үздэг. Харин хандив авсан төрийн байгууллагууд авсан юмаа тайландаа тусгадаг бол асуудал амар байх юм. Харамсалтай нь тэд тайлагнахгүй байгаад учир байгаа юм. Цаашид энэ асуудлыг зохистой болгоё гэж манай зөвлөх хэлсэн байгаа.

Г.Чагнаадорж: Тэр юм авсан өгсөн хүмүүс чинь зарлагын баримт энэ тэр гарын үсэг зурж байгаа биз дээ.

Б.Жигдэн: Тиймээ, манай аудитор болон Бороо гоулдынхан маш сайн хамтран ажилласан байна. Хандив өгсөн тал нь тооцоо баримтандaa тусгасан байгаа боловч цаад авсан нөхдүүд буюу Зүүнхараа, Баруунхараагийнхан авсан хандиваа тусгаж тайлагнаагүй байна.

Г.Чагнаадорж: Сум чинь улсын төсвөөс баяр наадмын зардал гэж санхүүжилт авч байгаа ш дээ. Зарим нь алтны компанидаас их юм авч байгаа.

Н.Дорждарь: Энэ тайландаа бас ярьж байна. Би татвар төлөгчийн дугаар байхгүй болон байгууллагын бүртгэлийн дугаар давхардсан гэдэг асуудлаар Сангийн яам болон Улсын бүртгэлийн газруудаас асууж байсан. Аудитынханаас асуухад, 2012 оны тайландаа хамрагдсан компаниудад бүртгэлийн дугаар давхардсан тохиолдол байна уу. Жишээгээр хэлнэ үү. Мөн түрүүний хандив тусламжийн талаар нэмж хэлэхэд, төрийн байгууллагууд хандив тусламж авахыг хориглосон хууль гарсан шүү дээ. Үүнийгээ яагаад хэрэгжүүлэхгүй байна вэ? Ер нь төрийн байгууллагууд яагаад тайлангийн сайн дурын мэдээллийг бөглөхгүй байна вэ гэдэг талаар Сангийн яамны хүнээс асуумаар байна.

Г.Зулай: Төсвийн тухай хуулиар төрийн байгууллагууд хандив тусламж авахгүй гэж заасан бөгөөд энэ нь 2013 оны 1 сараас хэрэгжиж эхэлсэн байгаа. Энэ тайлангийн хувьд 2012 оны тайлан хамрагдсан учраас хандив тусламж орсон байна. 2013 оноос хандив, тусламж авахгүй байгаа. Бүртгэлийн дугаар давхардаа талаар бидний хувьд татварын албанаас бүртгэлийн дугаарыг авдаг.

Д.Энхтуяа: Татвар төлөгчийн дугаар гэж тусгай дугаар байхгүй. Ер нь бол улсын бүртгэлийн дугаар, татвар төлөгчийн дугаар гэж олон дугаартай болвол төөрөгдөх будилах магадлалтай байх. Иймээс байгууллагуудад олгосон 7 оронтой тоо буюу бүртгэлийн дугаарыг ашиглаж байгаа. Давхардлын хувьд Улсын бүртгэлийн газраас дугаар олгодог. Энэ нь давхардаа ганц нэг тохиолдол байсан байх. Гэхдээ энэ нь 100-д нэг тохиолдол байж магадгүй. Тийм олон байдаггүй.

Б.Жигдэн: Манай зөвлөх хэлж байгаа. Бусад орнуудад регистрийн дугаараас хөөгөөд татвар төлөгчийн дугаар гэж олгодог юм байна. Тийм дугаар байхгүйгээс болоод бие биенийхээ өмнөөс татвар төлөх тохиолдолд давхардал гардаг. Тухайлбал би нэг жишээ хэлье. Манай Эрдэнэт үйлдвэрийг олон нэрээр нэрлэдэг. ГОК гэх мэтээр гэхдээ хүн болгон мэддэг учраас энэ бол Эрдэнэт юм аа гэж мэдээд байдаг. Харин жижиг шинэ компаниудыг хүн болгон мэдэхгүй ш дээ. Тэгэхээр энэ асуудлыг нухацтай авч үзэж энэ талаар арга хэмжээ авах хэрэгтэй юм шиг байна лээ.

Б.Батболд: Тайланд дурдахдаа компаниуд дээр яваад очихоор ОҮИТБС-ын талаар юу ч мэдэхгүй байна гээд байх юм. Бид өмнө нь тэднээс олон жил тайлан авч байсан яаж хамтарч ажиллаж байсан юм бол. Эсвэл тэд халтуурдаж байвуу эсвэл та нар цоо шинэ юм гаргаад ирэв үү? Мөн 2012 оны аудитад орсон 200 компанийн хэд нь ийм тохиолдол байсан бэ нэрээр нь гаргаж өгөөч. Дараагийн нэг асуудал бол цар хүрээ тогтоогоогүй гээд байх юм бид 40 саяас дээш гээд заагаад өгчихсөн байгаа ш дээ. Цар хүрээ гэж юуг хэлээд байгааг ойлгохгүй байна. Үүнийг тайлбарлана уу.

Б.Жигдэн: Би энэ асуудлыг тайлбарлай. Компаниуд бол арай гайгүй. Харин төрийн байгууллагуудад огт мэдэхгүй хүмүүс бас байна. Тухайлбал, Гаалийн ерөнхий газрын дарга нар ЕІТІ гэж юу юм бэ? Чи гадаадын мөнгө угаадаг газруудад мэдээлэл гаргаж өгөх гэж байна уу энэ тэр гэж байсан. Энэ юунаас болж байна вэ гэвэл сонгуулийн үр нөлөөгөөр хийгдсэн бүтэцийн өөрчлөлтөөс болсон байх. Өмнө нь гайгүй мэдээлэл аваад ойлголттой болсон хүмүүсийг бужигнуулаад шинэ хүмүүс томилогдсон нь үүний гол шалтгаан байсан байх. Түүнээс биш бүгдээрээ мэдэхгүй байгаа юм биш. Манай ажлын алба, ажлын хэсэг 6,7 жил зүтгээд суртал ухуулаг, соён гэгээрүүлэх ажил их хийсэн байгаа юм. Гэхдээ нэг, хоёр балгтай байгууллагуудаас болоод ийм дүгнэлтэд хүрээд байна. Иймд талиянгаа гаргадаггүй, хоцроодог нягтлан бодогчуудад арга хэмжээ авдаг, торгодог болгох хэрэгтэй юм. Тэгэж байж сахилгад оруулдаг юм. Би бол 50 жил нягтлан бодогч хийж байгаа хүн. Бид ОҮИТБС-ын дүрэм, шаардлага энэ тэр бичиг баримтуудыг уншиж танилцсан байгаа. Энэ нь өндөр шаардлага тавигдсан байна лээ. Дараагийн нэг хариулт нь, цар хүрээ тогтоох талаар 40 сая төгрөгнөөс дээш гэж гаргаснаа их том юм хийсэн гэж үзэж болохгүй. Манайх шиг орлогыг нь жагсаагаад 40 саяаас доош гарсаныг нь тасдаад хаячихдаг юм биш. Олон улсын хэмжээнд үүнийг сонгоходо маш том шалгуур үзүүлэлтүүдээр, нарийн шүүж гаргадаг юм байна. Хэдий хэмжээний төлбөрийг материаллаг гэж үзэх вэ гэх мэтчилэн. Жишээлбэл: Оюу толгой компанийн хувьд ярихад гаалийн хураамж гэдэг нь хилээр орох гарах болгондоо төлсөн мөнгө юм. Гаалийн хураамж гэдэг талаас нь авч үзвэл жижигхэн юм. Энэ нь 1000 төгрөгнөөс эхэлдэг. Гэхдээ хураагдаар байгаад бүтэн жил болоход 2,3 тэр бум төгрөг болж байгаа юм. Үүнээс үзэхэд гаалийн хураамжийг жижиг юм хаячихъя гээд хаячиж болохгүй. ОҮИТБС-ийн дүрмэнд гаалийн хураамжийг оруулна гээд заасан байна лээ. Иймээс бүгдээрээ дүрмээ маш сайн судлай. Тэгээд дараа жилийн тайлангаа илүү сайн хийцгээ гэдэг дүгнэлтэд хүрээд байгаа юм.

Э.Сумъяа: За, Манай материаллаг түвшинг дэмжсэнд Жигдэн гуайд баярлалаа. Тайлан дээр чинь арай өөрөөр бичсэн тал байна лээ. Үүнийгээ хараарай. Өөр санал байна уу.

Н.Баярсайхан: За түрүүн тайлан дээрээ аль болох татвар бага гаргахыг шаардсан. Энэ зөрүүг бага байлгах гэсэн үг үү. Мөн тайлан чинь иргэдэд аль болох ойлгомжтой байх ёстой юм биш үү. Би энэ тайланг сайн ойлгоогүй. Энэ талаар шахалт үзүүлсэн юм уу. Мөн аудитынхан мэдээлэл авч чадаагүй гээд байх юм. Тэгэхээр та нарыг мэдээлэл авч чадаагүй гэж ойлгож болох уу.

Б.Жигдэн: Түрүүний ажлын хэсгийн хурал дээр би хэлсэн. Бид бол зөвхөн тооны хойноос хөөцөлдөөд, хэдэн тоог нааш нь цааш нь холхиулаад, утсаар ч юмуу ам мэдээлэл аваад тоог тохируулахыг урьтал болгоогүй. Ингэх юм бол ач холбогдол багатай юм. Эцсийн дүндээ бодитой юмыг бодитойгоор гаргаж ирэх нь зүйтэй. Тайлангийн зөрүү ноднин 70,80 сая, энэ жил 300 сая байх нь сонин биш. Тайлангийн мөн чанар нь тоондоо биш мөн чанартай байгаа юмаа. Зөрүүг аль болох бага болгох шаардлагыг Цолモン гуй хэлж байна. Энэ нь даалгавар ч юм уу. Санал ч юм уу гэхдээ бид үүнийг хүлээж авахгүй ээ. Бид хараат бус аудитын зарчмаар л ажлаа хийнэ гэж хэлэх байна. Мэдээлэл дутуу өгөгдсөн гэдэг дээр зарим нь мэдээлэл өгөхгүй гэдгээ шууд хэлсэн. Зарим нь хойшлуулсаар байгаад, эсвэл амралттай байна, нягтлан мэднэ, хүн нь солигдсон шинэ хүн болсон юу ч мэдэхгүй гэх зэргээр мэдээлэл өгөлгүй өнөөдрийг хүргэсэн шалтгаануудыг

дурдаад байвал инээдтэй байх. Гэхдээ энэ нь ажил хийхэд бэрхшээл, зовлон байна. Бид 2 сар гаруй 10-аад хүнтэй баг ажиллаж чадлынхаа хэрээр хийгээд байна. Зарим компани тухайлбал Петро Чайна Дайчин Тамсаг Монгол гэдэг компани 2013 оны 10 сарын 31-ны өдөр албан бичгээр бидэнд баримт материал байхгүй тул зөрүүг арилгах боломжгүй гэдгээ мэдэгдсэн байна. Ингэж байгаа тохиолдолд бид яалтай билээ ямар хүчний байгууллага биш зөрүүг хэвээр нь тайлагнасан.

н.Радишууле: Нотлох баримт аваагүй бол бид тохируулга хийх боломжгүй. Иймд зөрүүг багасгах боломжгүй. Энэ нь олон улсын стандартад нийцсэн үйл ажиллагаа юм. Хэрэгтэй гэж үзвэл бид файлыг ажлын албанд өгч болно.

Д.Мөнхсайхан: Тайланг сонслоо. Тайланд хамрагдсан компаниудад Олон овоот гэдэг компани орсон байна. Миний мэдэхээр энэ компани тайлан гаргаагүй бөгөөд бид веб сайтан дээрээ тайлан гаргаагүй компанийн мэдээлэлийг тавьчихсан байгаа. Гэтэл Олон овоот нь 433 кг алт олборлоод борлуулчихсан гэсэн байна. Энэ мэдээлэлийг хаанаас авсан бэ, тайланг нөхөж гаргуулж авсан юу энэ талаар тайлбар авмаар байна.

н.Гантулга: Биднийг ажлын албанаас 200 компанийн тайланг хүлээн авахад 3 компани тайлангаа огт ирүүлгүй гэж байсан. Гэхдээ эдгээр нь 40 саяаас давсан дүнтэй байсан тул тайланг нөхөж авах шаардлагатай байна гэсний дагуу бид компаниуд руу хандсан байгаа. Утсаар мэйлээр удаа дараа хандаж, холбогдоны дагуу Таван толгой болон Олон овоот гэдэг 2 компани тайлангаа ирүүлсэн ба Доншин гэдэг нь тайлангаа ерөөсөө өгөөгүй юм. Олон овоот ХХК нэгдүгээр маягтаар тайлангаа ирүүлсэн бөгөөд түүндээ борлуулалтаа тусгасан байсан учраас бид нэгтгэлд оруулсан байгаа.

Д.Мөнхсайхан: Гэхдээ энэ чинь тайлан өгөөгүй гээд нэр нь зарлагдаад торгууль тавина гээд албан шаардлага явуулчихсан байхад тайланг нь нөхөн гаргуулсан байх нь асуудал үүсэх юм биш үү.

Б.Жигдэн: Бид энэ 2 компанийн тайланг их хөөцөлдөж байж авсан. Сайнаар ярвал сайн дураараа, муугаар ярвал та нөхдийн хүсэлтийн дагуу хийснээрээ асуудал үүсэж магадгүй юм. Гэхдээ энэ 2 компани материаллаг их дүнтэй компаниуд юм. Эдгээрийг тайланд оруулаагүй бол нөгөө зөрүү чинь улам өсөөд нилээн их зөрүү болох байсан байх. Тэгэхээр үүнийг хийсэн нь сайн уу муу юу гэдгийг дарга нар л мэдэх байх. Муу гэвэл тайлангаас хасаад хаячиж болно шүү дээ.

Н.Баярсайхан: Энэ нэгтгэл орох 200 компанийг хаанаас гаргаж өгдөг юм. Эдгээр нэрсийг ажлын албанаас гаргаж өгсөн юмуу. Тэгэхдээ энэ том энэ жижиг гээд хамаагүй ялгаад өгчихдөг юм уу?

Э.Сумъяа: за одоо асуух асуулт байхгүй бол саналаа хэлээд явчихъя.

Б.Жигдэн: Саяны асуудлаа юу болов.

Э.Сумъяа: Сангийн яамны тайлангаар 40 саяаас дээш татвар төлсөн компаниудыг оруулсан.

Ж.Гомбожав: Төрийн байгууллагаас авилга гэж хоёрдугаарт, бид нар ажлаа 8 сараас эхэлсэн гээд байна. Эрхтэн ажлаа эхлээд 1 сарын дотор хийгээд дуусгаж болоогүй юу.

Б.Жигдэн: Би 7 сард амраад хөдөө явж байсан. Гэтэл гэнэт утасдаад 7 сарын 29-нөөс ажлаа эхлэхгүй бол болохгүй гэж ажлын албанаас хэллээ гэсэн. Тэгээд гадаад зөвлөх маань ирээд л бид ажилдаа орсон. Ер хүмүүс амарч орж ирэхээр 9 сараас эхлээд нэг сард багтаагаад хийчих боломжтой юм байна гэж манай гадаад зөвлөх хэлсэн. Гэрээн дээрээ бүх компанийн тайлан ирж дууссан нөхцөлөөр бид ажлаа эхлэх ёстой. Хамгийн сүүлийн тайлан 10 сарын 30 нд ирсэн. Гэхдээ бид тайлан оройтож ирсэн гээд ажлаа хойшлуулаагүй аль болох хугацаандаа амжиж Үндэсний зөвлөлд оруулах гэж зорсон байгаа.

Н.Гантулга: Тайлангийн гол зөрүү нь үнэ өртөг нь тодорхойгүй хандив тусlamжид байгаа юм. Өөрөөр хэлбэл компаниудын зүгээс ямар нэгэн баяр наадмыг зохион байгуулад өгчихсөн мөнгөн хэмжүүр нь тодорхойгүй зардал, эсвэл тодорхой мөнгө гаргаад ямар нэгэн юм худалдаад аваад өгчихсан, эсвэл төсвийн байгууллагын барилга бариулаад төлбөр тооцоог гүйцэтгэх байгууллагад төлчихсөн гэх мэтээс шалтгаалж байна. Үүний нэгэн томоохон жишээ нь Бороогоулд компанийд гарсан. Эднийх эрүүл мэндийн байгууллагад зориулж 5 тэрбум төгрөгний барилгын өртгийг төлсөн байгаа. Энэ талаарх мэдээллийг авах гэж холбогдох бүх байгууллагууд, эрүүл мэндийн яамаар очсон. Хандив тусlamжийг хүртэж байгаа төсвийн байгууллагуудад энэ талаарх мэдээлэл байдаггүй юм байна лээ. Хэдийгээр 2013 онд барилгаа хүлээгзээд авчихсан байсан ч санхүүжилтийг нь нарийн тулгах боломжгүй зэрэг асуудлууд тулгарч байсан. Эцэст нь бид Эрүүл мэндийн яамнаас ийм хэмжээний өртөгтэй барилгыг хүлээн авсан гэсэн бичгийг хүлээн авч байж тайлангийн тохируулгыг хийсэн.

Э.Сумъяа: Өөр асуух асуулт байнауу?

Н.Дорждарь: Тайланд газрын тос ураны компаниуд яаж хамрагдсан бэ? Лицензээрээ юу. Тайланг харахад “Мон атам” компани ороогүй юм шиг байна. Эднийх лицензтэй юу.

Н.Гантулга: Тайланд газрын тос ураны 14 компани орсон. Дандаа лицензтэй компаниуд хамрагдсан.

Ш.Цолмон: Мон атам компанийн лицензийн талаарх мэдээллийг бас шалгаж үзэх нь зүйтэй юм.

Н.Алгаа: Бид тайланг сонсож танилцлаа. Тайлангийн зөрүү бол жил болгон давтагддаг. Тайлангийн үзүүлэлтүүдээ сайн эргэж харж тогтоор байгаа юм. Жилийн жил 10-20 компаниуд нийт орлогын 80 хувийг эзэлж байгаа юм. Тэр үлдэх 20 хувийг тохируулахад маш их ажил уддаг. Энэ нь ямар ач холбогдолтой байна вэ. 22 төрлийн татвар хураамжийг бүгдийг оруулах ямар шаардлага байгаа юм бэ. Үүнийг хасаад ажлаа цомхон шуурхай болгоё. Үүнийг би жил бүр хэлдэг. Мэдээллийг түгээх ажлаа хүртээмжтэй болгомоор байна. Олон улсын жишгээр олборлох компаниудаа оруулах хэрэгтэй. Манайх шиг бүгдийг хөөцөлдөж явдаг улс орон байхгүй. Цаашдаа ажлын хэсгээрээ материаллаг байдлыг өндөрсгөөд, ажлыг шуурхай болгох хэрэгтэй байна. Төлбөр хураамжууд бүгд орох хэрэгтэй юу.

Тухайлбал, гаалийн хураамж гэх мэт. Замын хураамж гэж байж л байгаа ш дээ. Зарим газарт баримт байхгүй тийм юм байгаа. Тайлангийн маягтаа боловсронгуй болгох хэрэгтэй байна. Наадмын энэ тэр зардлын хандив авсан тал нь тайлагнахгүй байна. Иймээс энэ хандив тусlamжийг орон нутагт нь нээлттэйгээр танай энэ компани ийм хэмжээний хандив тусlamжийг ийм байгууллагад өгсөн байна гэдгийг мэдээлдэг болох нь зүйтэй юм. Тэгэхээр ил тод байдлын хууль гарахаас өмнө 3 талаасаа ажлын хэсэг гаргаад юуг ил тод болгох вэ гэдгийг хэлэлцээд өөрийн асуудлаа боловруулаад зөвшилцэлд орох асуудал чухал болоод байна. Эхлээд тус тусдаа ажлын ахлагч томилоод хариуцлагатай ажиллая. Баяртайхан иргэний нийгэмээ удирдаад, би хувийн хэвшлээ, төрийнхөн бас нийлээд асуудлаа тогтох боловсруулах хэрэгтэй. Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

Н.Дорждарь: Тайланг хараад гайгүй сайн хийгдсэн байна. Гэхдээ тайлангийн урд хэсэгүүд хойд мэдээлэлтэйгээ авцалдаж өгөхгүй байна. Жишээлбэл: хөрөнгө оруулалтын мэдээлэл гэх мэт. Мөн гэрээний судалгаа хийсэн байна. Энэ бол сайн ажил болсон байна. Та бүхнийг энэ талаар мэдээлэл хийх байх гэсэн боловч ярьсангүй. Тэгэхээр хойд талд байгаа мэдээлэлүүдээ тайлбарлаад урд талд нь оруулчихвал болохгүй юу гэсэн санал байна.

Д.Энхтуяа: Тайланд хураамжийг аудитлах шаардлагагүй гэсэн Алгаа гуайн саналтай санал нэг байна. Илтгэлд дурьдсанчлан хуулийн дагуу авч байгаа татвар төлбөр, хураамжуудыг дэндүү олон төрийн байгууллагууд (Газрын алба, Усны газар, АМГ, Автомотээврийн газар, Улсын бүртгэлийн алба гэх мэт) хурааж авдаг боловч нэгдсэн сүлжээ байхгүй болон орлогыг бүртгэх программ хангамжаас асуудлаас болоод ЗГ-ын тайлан гаргалт- ЗГазар авсан орлогоо ил тод цаг хугацаанд нь тайлагнахад муугаар нөлөөлдөг. Иймд орлогоо бүртгэхдээ “ухаалаг төр”-ийн зарчмаар ажиллах талаар ЗГ-т санал дүгнэлт хүргүүлэх хэрэгтэй.

Н.Болормаа: Алгаа гуайн хэлсэнтэй санал нэг байна. Ер нь энэ тайлан хэнд зориулагдсан юм бэ. Ард иргэдэд зориулагдсан юм уу. Татвар гэдэг бол бүхэл бүтэн том систем байгаа. Харин хандив тусlamж нь ил тод байдлыг тайлагнах асуудал юм. Гэтэл төрийн байгууллагууд нь хандив тусlamж авахгүй гээд заачихсан байдаг. 2012 оны тайланд Далайван аудитын талаар миний сэтгэл маш хангалуун байгаа. Мэргэжлийн хүний хувьд хараад ажил хэрэгч байдал, арга барил нь таалагдсан. Хамтран ажиллахад таатай байсан гэдгийг хэлмээр байна.

Б.Батболд: Би үнэндээ энэ хүмүүстэй санал нийлэхгүй байна. Бид нар ОҮИТБС-ын шаардлагыг үзэж байхад бүх юм ил тод байна гэж заасан байдаг. Олон улсын стандартаар төлсөн авснаа тайлагнахыг л шаардаж байгаа. Юу олж байгаа юм түүнээс юу олж байгаа юм бэ. Жижиг хураамж төлбөрүүдийг материаллаг бус гээд хасаад хаячихаар юу хийх гээд, юуг ил тод болгох гээд байгаа юм бэ? Яг орон нутгийн хувьд ч компаниуд итгэл үнэмшилтэй байх хэрэгтэй. Танай компани газар ашиглаад юу олж байгаа, түүнээсээ орон нутагт татвар төлж байгаа. Тэр төлсөн татвараас тухайн сумын иргэд цалингаа авч байгаа гэдгийг ойлгуулах хэрэгтэй ш дээ. Тэгэхгүй бол хөдөөний иргэд яаж ойлох юм бэ. Тухайн компани татвар төлдөг ч юм уу үгүй ч юм уу гэж хоорондоо ярьдаг ш дээ. Авиалгал авдаг нь цаагуураа идэж уудаг ч юм уу гэж боддог шүү дээ.

Иймээс юмаа ил тод болгох хэрэгтэй. Олсон, авснаа ил тод болгох хэрэгтэй. Олон улсын стандартад ил тод болгоно гээд заачихсан юмыг бид нар хасаад байхаар чинь юу болох вэ? Жижиг гэлтгүй ил тод болгох хэрэгтэй юм. Нэгэнт л санаачилгад нэгдсэн юм чинь олон улсын санаачилгыг дагах л ёстай. Хэрвээ тэрнийг дагахгүй гэж байгаа бол бид нар энэ санаачилгаас гарах хэрэгтэй. Иргэний нийгмийнхэн ч энэ талаар ярих хэрэгтэй. Тэгэж байж санаачилгад нэгдсэнийн ач тусыг гаргах хэрэгтэй юм ер нь ЕІТІ-ийн Нарийн бичгийн дарга нарийн газарт хандсан ч болно шүү дээ.

Н.Баярсайхан: Энэ жилийн тайланг харьцангуй сайн болсон гэж үзэж байна. Энэ тайланг орон нутгийн төлөөлөл, ЗДТГазар, иргэний нийгмийнхэн ашиглаж болохуйц энгийн бичвэрээр бичиж болохгүй юу. Хоёрдугаарт, тайланг хэрхэн яж ашиглах талаар зааварчилгаа, аргачлалыг тайлангийн эхэнд оруулж өгвөл зүгээр байна. Тайланд эрхзүйн орчныг оруулж өгөх хэрэгтэй байна. Тайланд үүсээд байгаа зөрүү нь юунаас болоод үүсэв, түүнд хууль эрхзүйн орчин нөлөөлж байна уу гэдэг дээр дүгнэлт, зөвлөмжийг оруулвал зүгээр болов уу гэж үзэж байна. Төрийн өмчийн оролцоот компаниудын мэдээллийг тусад нь нарийн харуулвал зүгээр байна. Тайланд тайлагнах татвар хураамж болоод компаниудын том жижиг гэж ялгахгүй байх нь зүйтэй. Аудитын компани ч энэ ажлыг хийхэд хэцүү байлаа гэсэн мессежийг их өгөх хэрэггүй байхаа. Хамгийн гол нь тайланд гарч үр дүн, мэдээллийг бид цаашид хэрхэн яж ашиглах вэ гэдгийг ярих цаг нь болсон юм байна. Тэгэхгүй байнга л тайлан яж гаргах вэ гэж яриад байх нь ямар вэ. Шаардлагад нийцсэн орлогыг тайлагнах талаар талууд ярилцсан учраас одоо энийг хасъя, цөөльье гэж ярьмааргүй байна.

н.Очирлхам: Би төрийн өмчийт компанийд ажилладаг. Баярсайхны хэлсэнтэй санал нэг байна. Бид ил тод байдлаа тайлагнаад явдаг. Манайх олон байгууллага, компаниудтай хамтран ажилладаг. Төрийн өмчид компани дээр чинь жижиг хувийн компаниуд ажиллах гээд байна. Энэд байгаа Сангийн яам, татварын хүмүүс анхааралдаа аваач гэсэн үүднээс хэлж байгаа юм. Худалдан авалт дээр шахааны бизнес чинь гараад байна. Манайтай хамтран ажиллаж бараа нийлүүлж байгаа компаниуд нь дандаа татвараас зугтаасан, хуулиас зугтаасан байдалтай байдаг. Наад захын НӨАТ гэх мэт. Тэд өчнөөн саяар наймаа хийж байгаа мөртлөө НӨТ төлөгч биш байдаг. Манай журманд болохоор заавал НӨТ төлөгчтэй харьцана гээд заасан байдаг гэсэн хэдий ч бид эрэлт хэрэгцээний дагуу яалт ч үгүй тэднээс худалдан авахад хүрдэг. Сэлбэг хэрэгсэл нь сонголт байхгүй, элбэг биш учраас. Үүнээс гадна нүүрс худалдан авч байгаа компаниуд нь өмнө жил нь нэг нэрээр ирээд дараа жил нь нэрэн дээрээ нэг үсэг нэмээд л өөр компани гээд хүрээд ирдэг. Гэхдээ яг өмнө нь ирж байсан нөгөө хүн нь хүрээд ирдэг. Энэ мэтчилэн татвараас зугтаах байдал их байна. Би нэр дурдаад компаниудын нэр төрд халдаад яах вэ. Энд байгаа иргэний нийгэм, компани, төрийн байгууллагууд энэ асуудал руу анхаарлаа хандуулах зүйтэй байх гэдгийг хэлэх гэсэн юм.

Ж.Гомбожав: Тайланд өгч байгаа зөвлөмжүүд нь их үр дүнтэй саналууд байна. Энэ нь 2012 оны манай ажлын хэсгийн ажлын үр дүнгийн нэгээхэн хэсэг гэдэгт санал нэг байна. Монголын ард түмэн байгалийн баялагаас хүртэх ёстай юмаа хүртэж чадахгүй байгаа. Энэ нь татвар хураамжаа авах газрууд нь авч чадахгүй байгаатай холбоотой. Хөдөө орон нутгийн хүмүүсийн санал хүсэлтийг сонсож байхад уул уурхайн орлогыг ил тод болгох талаар ярьж байна. Үүний нэг

төрөл нь хандив юм. Тайлангийн хугацаа 2 жилийн дараа гарч байгаа нь уг ажлын ач холбогдлыг супруулаад байна гэж үзэж байна. Олон улсын тайлан нь 2 жилийн дараа гардагаараа гарч байг харин иргэний нийгмүүд урьчилсан байдлаар ард иргэдэд танилцуулж байх нь зүйтэй гэж орон нутгийн чуулган дээр хүмүүс санал оруулж байсан. Энэ нь манай ажлын хэсгээс маш товчхон бэлтгээд мэдээлэх хэрэгтэй юм. Мөн нэг талаас компаниуд тайлагнаад байхад төрийн байгууллагууд нь тайлагнахгүй байна гэж. Энэ чинь цаанаа асуудалтай байгаа болохоор тайлагнахгүй байгаа гэсэн уг юм. Үүнийг бас анхаарах хэрэгтэй байна. Баярлалаа.

Л.Долгормаа: Бидний хийж байгаа ажлыг ил тод болгоод өгөөч ээ. Цаашдаа энэ зөрүү нь юунаас болж гарсан талаар тайлбарлаж олон нийтэд мэдээлэх хэрэгтэй байна. Нөхөн сэргээх асуудлын талаарх юм. Компаниуд тодорхой хэмжээний мөнгийг орон нутагт өгдөг. Эцэст нь авсан, өгсөнөө тайлагнаж ил тод болгох хэрэгтэй байна.

Э.Сумъяа: За санал дууслаа. Консервиумын зүгээр уг хэлэх гэж байна.

н.Радихууле: Би хариултыг нэгтгэе. Ихэнх асуудал цар хүрээний судалгаагаар гарчих байх. Бид Олон улсын стандартын дагуу ажлын цар хүрээ, татвар, ямар маягтаар тайлангаа гаргахаа тодорхойлох ёстой. Ингэснээр дээрх асуудлууд шийдэгдэх байх. Иргэний нийгмийн байгууллагууд төлбөр бүрийг дэлгэрэнгүй харахыг хүсэж байгааг би ойлгож байна. Энэ нь амьдрал дээр хэцүү зүйл юм. Засгийн газрын ихэнх орлого буюу 99 хувийг тайлагначихаад байхад ерөнхий ойлголтыг авч болно. Нэгтгэлийн гол үр дүн нь ажлын цар хүрээг судалж, ямар ямар татварыг оруулах нь чухал вэ гэдгийг тогтоох нь чухал юм. ОҮИТБС-ын тайлан нь авилгалыг илрүүлэх тайлан биш энэ нь Засгийн газар ямар татвар, төлбөр авсан гэдгийг харуулах тайлан гэдгийг ойлгох нь чухал юм. Тайланда олон зөвлөмжүүд бий. Дараа жилийнхээ ажлын цар хүрээний судалгаагаа эртхэн хийх хэрэгтэй. ОҮИТБС-ын тайлан бол мэргэжлийн үтэй, мэргэжлийн хүмүүст зориулсан тайлан юм. Тайлангаас хамгийн чухал хэсгүүдийг оруулсан гарын авлага гаргаж болно. Бидний хувьд стандартаа мөрдөж байгаа учраас тайланг ингэж нэгтгэсэн.

Б.Жигдэн: Сая зөвлөх хэллээ. Судалгаагаа сайн хийе гэж. Энэ тайлан чинь стандарттай учраас өөрсдөө стандарттаа сайн судлаад стандарттаа баримтлах хэрэгтэй байна. Маягтуудыг баталгаажуулаагүй байна. Ганцхан компани баталгаажуулаагүй байна. Энэ нь санхүүгийн тайланг баталгаажуулсан тухай биш юм. Долоон маягтын доод талд нь хөндлөнгийн аудитаар баталгаажуулсан байх хэрэгтэй юм гэнэ. Мөн түүнийхээ ард талд нь холбогдох баримт нотолгоонуудыг хавсаргаж явуулж байвал заавал түүнийг тодруулах гээд тэдэнтэй хөөцөлдөөд байх шаардлагагүй юм. Тэр материалуудаа хараад хийчих юм байна лээ. Ер нь бол материаллаг хэмжээгээ зөв тогтоох нь чухал юм. Аливаа юмыг материаллаг үнэ цэнээр нь үнэлдэг олон улсын сонгодог арга байдаг. Үүнийг ашиглах нь зүйтэй юм. Ер нь бол ОҮИТБС нь татварыг асуудлыг хариуцахгүй. Татвар чинь бүхэл бүтэн субъект болоод оршиж байгаагийн хувьд татвар төлөгч нартайгаа тэмцэх хэрэгтэй. Асуудал болгоныг ОҮИТБС-тай хамж холих хэрэггүй гэж манай зөвлөх хэлсэн байгаа. Цаашдаа үүнийг нилээн даацтай хийх нь зүйтэй юм. Аудитын байгууллага ажил хийхэд залхуураад байх юм байхгүй. Бид бол аль болох их ажил аваад 3,4 сар суухад татгалзах юмгүй. Энэ бол сайхан санал байна.

Ш.Цолмон: Мэдээлэл хийсэн аудитынхандаа баярлалаа. Бид маргаашийн дотор хурлын тэмдэглэлийг бичээд та нарт явуулна. Та бүхэн үзэж танилцаад саналаа ирүүлнэ биз. Зөрүүний тухайд заавал ингэ гэж шахсан юм байхгүй. Та хэдийн яриа бас хоорондоо зөрсөн. Та бүхэн зөв ойлголттой байх ёстай.

Б.Жигдэн: За баярлалаа.

Э.Сумъяа: Асуудал дуусаагүй байна. Тайлан боломжийн гарч ирсэн байна. Та нар үйлдвэрлэл, тусгай зөвшөөрөл зэрэг эх сурвалжийг авсан огноогоор нь тавиарай. Одоо тоонууд өөрчлөгдсөн байгаа шүү. Авсан он, сар, өдрөө зөв бичээрэй. Бидний хэлсэн зүйлүүдийг хийвэл хийгээрэй. Нэр томъёо энэ тэрүүдээ эргэж сайн хараарай. Зарим нь буруу л яваад байх шиг байна. Мэдээлэлд дурдсанаар татвар төлөгчийн дугаартай байх ёстай гэж байгаа. Сангийн яамныхан, татварынхан энэ зөвлөмжийн талаар та бүхэн өөр өөрийн байгууллага дээр сайн танилцуулах хэрэгтэй шүү. Аудитын байгууллага шийдвэрт тусгасан зүйлүүдийг хийгээд Үндэсний зөвлөлийн хурлаас өмнө танилцуулахад бэлтгэх хэрэгтэй. Цолмонгийн хэлээд байгаа гэрээнд хийхээр тусгасан зүйлүүдээ сайн тохироорой.

Э.Сумъяа хурлын шийдвэрийн төслийг уншиж танилцуулав.

Н.Баярсайхан: Хурлын шийдвэр дээр санал байна. Ажлын хэсгийн зүгээс гарсан санал зөвлөмжийг харгалзан биш тайландаа тусгаж гэж оруулмаар байна. Санал хэлэхээр өөдөөс ингэж ойлго, тэгэж ойлго гээд байх юм. Тайлбар битгий хийгээд бай. Тэр бол ойлгомжтой. Тэгэх юм бол өдөржин хэлэлцсэний үр дүн байхгүй болно.

Н.Алгаа: Гэрээ бол гэрээ, ажил бол ажил байх ёстай. Зөвлөмж бүрийг тусгаж чадахгүй. Татвар төлөгчийн дугаарыг одоо тусгах ямар ч боломжгүй. Тайланд тусгахыг нь тусгаад тусахгүйг нь тайлбар оруулах хэрэгтэй. Ажил сайн хийсэн хүмүүсийг заавал шийтгэх ёсгүй. Хураангуй тайлан гаргах тараах зэрэг нь бидний хийх ажил юм. Төр хийх ажлаа хийх, татвар хийх ажлаа хийх л хэрэгтэй. Өөрсдийн хийх ажлаа бусдад даатгах хэрэггүй. Харин ажлын хэсгээ өргөтгөөд ажлаа түргэвчилэх нь бид нарын үүрэг. Иймээс ажлын хэсгийн гишүүдийн санал зөвлөмжийг “харгалзан” гэж оруулах нь зүйтэй.

Э.Сумъяа: За баярлалаа. Манайх чинь гурван талын оролцоотой гэдгийг та бүхэн харж байгаа байх.

Д.Энхтуяа: Далайван аудитад хандаж асуух асуулт байна. Тайланд Засгийн газрын шийвлэрлэгдээгүй зөрүү гэсэн дүн дээр татварын албанаас хамаарах их зөрүү байгааг дараагийн танилцуулгаас өмнө тодруулга хийж багасгаж болох уу.

Б.Жигдэн: Болно

Э.Сумъяа: Үндэсний зөвлөлд танилцуулах тайлангаа маш хураангуй хийгээрэй. Өнөөдрийнх шиг ийм урт танилцуулах юм бол Сайд дарга нар завгүй байдаг тул гараад яваад өгнө шүү. За аудитынхандаа талархалаа илэрхийлье.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:1. Монгол Улсын ОҮИТБС-ын 2012 оны урьдчилсан нэгтгэл тайланг хэлэлцээд ажлын хэсгийн гишүүдээс хуралдаан дээр гаргасан саналыг судалж тусган, одоо хүлээгдэж байгаа тулгалтын тооцоогоо нэмж нэгтгэн, тоо баримт, уг хэллэг, найруулга зүйн алдаагсайтар хянаж, гэрээнд заасан ажлын даалгаврыг бүрэн гүйцэтгэж Монгол Улсын ОҮИТБС-ын 2012 оны нэгтгэлийн эцсийн тайланг бэлтгэн Үндэсний зөвлөлийн хуралдаанд оруулж хэлэлцүүлэхээр тогтов.

2. Монгол Улсын ОҮИТБС-ын 2012 оны нэгтгэл тайланг Үндэсний зөвлөлийн хуралдаанаас өмнө бүрэн эцэслэх ажлыг Ажлын албатай тохиролцож, гэрээний үнийн дүнгийн 80 хувийн төлбөрийг аудитын консорциумд олгохыг Ажлын албанд зөвшөөрөв.

3. Энэ оны 12 дугаар сарын 15-ны дотор гэрээний хавсралтад заасан дараах ажлыг дуусгахыг аудитын консорциумд зөвлөмж болгов:

а/хандив тусlamжийн судалгааг нэг бүрчилэн тусад нь гаргах;
б/төлбөр орлогын задаргааг аймаг, төрийн байгууллагаар гаргах;
в/компани, төрийн байгууллагуудтай холбогдон гарсан зөрүүнүүдийг шийдвэрлэх арга замын талаар санал боловсруулах;

г/ашигт малтмалын нөөц, тусгай зөвшөөрөл, үйлдвэрлэл зэрэг ерөнхий мэдээллийг холбогдох мэргэжлийн байгууллагуудын мэдээллийн сантай тулган нягталж, эх сурвалжийн хамтаар эцэслэн боловсруулж, хэвлэн нийтлүүлэхэд бэлтгэх.

4. Ажлын хэсгийн хуралдаанд гишүүд, түүнийг орлож ирсэн төлөөллүүд аудитын консорциумаас гаргасан Монгол Улсын ОҮИТБС-ын 2012 оны нэгтгэл тайланд тусгагдсан асуудал, зөвлөмжийн төслийг удирдлагадаа танилцуулж, зөвшөөрч байгаа эсэхийг албажуулж өөрийн төлөөллийн ахлагчид хүргүүлэх, төлөөллийн ахлагч нар бусад гишүүдийнхээ саналыг нэгтгэнэцэслэж Ажлын албанд 12 дугаар сарын 6-ны дотор хүргүүлэхийг төлөөллийн ахлагч нарт даалгав.

5. ОҮИТБС-ын 2012 оны нэгтгэл тайлан гаргах явцад тулгарсан бэрхшээл, илэрсэн зөрчил, алдаа сургамж бүрийг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд гишүүд нь оролцдог байгууллага, аж ахуйн нэгжбүрээр судалж, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг тухайн байгууллага, аж ахуйн нэгжүүд дотоод ажлын төлөвлөгөөнд тусгаж ажиллахыг Ажлын хэсгийн гишүүдэд даалгав.

II. ХЭЛЭЛЦСЭН нь: Монгол Улсын ОҮИТБС-ын 2013 оны ажлын төлөвлөгөөний биелэлтийн явц

Э.Сумъяа: За манай хурал тарах болоогүй үргэлжлүүлэн дараагийн асуудалдаа орно. Харин аудитынхан явж байж болно. Одоо 2013 оны ажлын гүйцэтгэлийн талаар ярина.

Н.Алгаа: Зарчмын нэг санал байна. Бид төлөвлөгөөний биелэлтийг урьдчилан танилцсан бөгөөд анхнаасаа баталахад оролцож байсан болохоор ерөнхийд нь мэдэж байгаа. Иймээс хурлаа хялбар болгохын тулд 2013 оны төлөвлөгөөний яг болохгүй байгаа хийж амжаагүй асуудлаа товчхон танилцуулчихвал ямар байна.

Гишүүд: Тэгье ээ. Зөвшөөрч байна.

Э.Сумъяа: Тэгэхээр гарсан саналын дагуу 2013 оны төлөвлөгөөний гол биелэгдэхгүй байгаа асуудлуудаа л ярь. Яагаад биелэгдэх болсон шалтгаан нь юу байв, хойшлогдсон нь ямар ажлууд байна гэдгээ л товчхон ярьчих.

Ш.Цолмон: Эхний гол асуудал бол Мөн орон нутагт чадавхийг бэхжүүлэх сургалтыг зохион байгуулах зэрэг ажлууд байсан. Гол хийгдээгүй ажил нь Үндэсний зөвлөлийн хуралдуулахтай холбогдсон асуудал буюу ОҮИТБС-ын хуулийн төслийн санал бэлтгэх, төсөл өргөн барих, ОҮИТБС-ийн хуулийг батлуулах зэрэг ажлууд маань зарим нэг нөхцөл байдлаас болоод биднээс шалтгаалахгүйгээр хойшлогдох болоод байна. Тухайлбал, хуулийн томоохон баримт бичгүүд дээр нилээд нухацтай, болгоомжтой хандаж ажиллах нь зүйтэй юм байна гэж үзэж тайван хандаж байгаа. Өөр нэг томоохон асуудал бол цахим тайлангийн ажил буюу 41 дүгээр ажил хоцрогдох маягтай байна. Дэлхийн банкнаас зөвлөхдөө энэ ажлыг орон нутгийн хаа хамаагүй жижиг компаниар хийлгэх ажил дээр болгоомжтой хандах хэрэгтэй гэсэн зөвлөмж өгсний дагуу Европын банкны санхүүжилтээр гадаад зөвлөх түрүүний долоо хоногт ирж ажиллаад явсан байгаа. Энэ үеэр цахим тайланд шаардлагатай анхан шатны судалгаа хийгдсэн. Энэ ажил цаашдаа он дамжаад зайлшгүй хийгдэнэ. Манай компанийн төлөөлөл, ажил хариуцсан хүмүүс ирсэн зөвлөхдөө уулзсан байгаа. Мөн гадаад судалгааны ажил энэ ондоо багтаж хийгдэж дуусах байх. Мөн хэвлэл мэдээллийн ажилтнуудын хоёр дахь сургалт болно. Үүнийг Цэрэнжав хариуцаж хийлгэх байгаа. Төрийн захиргааны байгууллагуудын хоёр дахь сургалт бас болох ёстой. Сургалтууд нь хийгдээгүй ажлууд Мөн интерконсалтингийн хүмүүсийн хийж байгаа гэж та бүхэнтэй уулзаж судалгаа авч байгаа. Тэрний дүгнэлт гарах байх. Цаашилбал гадаад судалгааны нэг ажил байгаа. Европын банкны санхүүжилтээр хэрэгжих энэ ажил нь энэ ондоо багтхаарагүй болж байна. Европын банкнаас Гана улс руу явж болох санал тавьсан байгаа. Манай гишүүд энэ тал дээр хаашаа явах нь дээр вэ гэдгийг судлаад саналаа өгвөл сайн байна. Бусад ажлууд нь хийгдсэн байна. Дараагийн долоо хоногт ажлын хэсгийг хуралдуулахаар ярьсан байгаа. Үүнд, орон нутгийн дэд зөвлөл байгуулах болон Хүний эрх хөгжил төвийн судлаачийн Үндэсний зөвлөлийн хурлын шийдвэрийн биелэлтэд хийсэн судалгааг танилцуулна. Хөдөө орон нутагт хамтран ажиллаж

цаг заваа зарцуулж, хүчин чармайлт гаргаж байгаа ажлын хэсгийн гишүүдэдээ талархлаа илэрхийлье. /Төлөвлөгөөний биелэлийг хавсаргав/

Б.Батболд: 2013 оны ажлын төлөвлөгөөнд нэг ажил нэмж оруулмаар байна.

Ш.Цолмон: Ондоо багтаж хийгдэх боломжтой бол бололгүй яах вэ.

Б.Батболд: Ажлын хэсгийн гишүүдийг Оюутолгой төсөлтэй танилцуулах ажил байгаа юм байна. Бүх зардал мөнгийн Оюутолгой гаргах юм гэнэ. Тэгэхээр ажлын албанаас зардал гарахгүй юм чинь яваад ирвэл ясан юм бэ. Гишүүдээс санал аваад энэ ондоо багтаад явах хэрэгтэй юм байна лээ. Төсөв энэ оны ажилд орсон байгаа юм гэсэн.

Л.Долгормаа: Оюутолгойн юутай танилцах юм бэ?

Б.Батболд: Үйл ажиллагаатай нь л танилцана шүү дээ. Оюутолгойн Лхамаа өөрөө ажлын хэсэгт байдаг болохоор энэ саналыг тавиад байгаа юм байна.

Э.Сумъяа: Энэ чинь нөгөө 10 мянган долларын асуудалтай адилхан юм болох юм байна. Оюутолгой сэтгүүлчид ирүүлээчээ гээд баахан сэтгүүлчид аваачаад дараа нь түүнийхээ зардлыг ЗГХЭГазарт 10 мянган долларын хандив өгсөн гээд тайлагнасан байсан. Наадах чинь түүний араас орох хэрэг байна шүү.

Ш.Цолмон: Би энэ дээр болгоомжтой хандаж байна. энэ чинь ялгаагүй хувьцаа эзэмшигчдийн мөнгө шүү дээ. Тэр чинь цаанаа компаниудын мөнгө байгаа. Гишүүд өөрсдөө л мэд.

Н.Алгаа: Би бодохдоо Оюутолгойн шинэ төслийн үйл ажиллагааг ажлын хэсгийн гишүүд үзчихээсэй гэж Лхамаа бодсон байх гэж бодож байна. Тэгэхээр үүнийг дэмжиж байгаа ажлын хэсгийн хэдэн гишүүн байна тэдний тоог гаргаад зардал мөнгийг нь тооцоод манай руу мөнгийг нь аваад зохион байгуулж болох юм гэсэн саналтай байна. Оюутолгой бол хамгийн том бүтээн байгуулалттай төсөл юм. Би мэргэжлийн хүний хувиас хэлэхэд орчин үеийн техник технологи, далд уурхай, байгаль орчны нөхөн сэргээлт, хажуугийн далангийн мониторингийн ажил зэрэг олон янзын юм байгаа учраас очоод үзчихсэн нь зүйтэй юм гэж хэлмээр байна. Тэгээд 12 сард амжихгүй бол нэгдүгээр сард байж болох юм. Ямар нэгэн байдлаар бид нар наад асуудлыг чинь зохион байгуулья.

Ш.Цолмон: Энэ санхүүгийн тал дээрээ манайд бас боломжгүй байгаа юм.

Э.Сумъяа: Наадахыг чинь тэгээд тайлан дээрээ хандив гээд л оруулаад ирнэ ш дээ.

Н.Алгаа: Манайх бол хуулиараа хандив авч болно гээд заачихсан учраас ийм замаар шийдэх боломж байна аа.

Ш.Цолмон: Алгаа гуайн хэлснээр Уул уурхайн ассоциаци байж болох юм. За энэ асуудлаа ингээд шийдчихсэн. Бас нэг асуудал бол ажлын хэсгийн зарим гишүүдээс шинэ жил хийе гэсэн санал гарсан байгаа. Гэхдээ энэ нь санхүү

талдаа жаахан хэцүү юм байна лээ. Дэлхийн банкны зөвлөмжийн дагуу иймэрхүү юм зохион байгуулж болно гэсэн байгаа. Хэрвээ та хэдийг зөвшөөрвөл. Төрийн байгууллагын жишгээр архи дарсгүй, аль болох зардал бага л тэмдэглэх байх.

Н.Баярсайхан: Дэлхийн банкнаас зөвшөөрөөд мөнгө нь байгаа юм бол яах вэ дээ.

Б.Дэлгэрмаа: Дэлхийн банкны зөвлөх Энхзаяа боломж байж болно гэсэн. 2013 оны ажил дээр нэмж орон нутагт зохион байгуулсан бүсийн семинарын талаар товчхон мэдээлэл хиймээр байна. /Мэдээлэлийг хавсаргав/

Н.Баярсайхан: Ажлын албаны төсөв мөнгө юу болж байна энэ талаар.

Ш.Цолмон: Үндэсний зөвлөлийн хурлын өмнө нилээдгүй ажлын амжуулна. Хоёрдугаарт, аудиторуудын хөрөнгө мөнгөний хувьд Дэлхийн банкны санхүүжилтийн 250,000 доллараас 190,000 долларыг зарцуулаад байна. Ирэх оны 5 дугаар сарын 31 хүртэл явна. Дөрөвдүгээр шатны төслийн хүсэлтийг Эдийн засаг хөгжлийн яаманд явуулсан хүлээлтийн байдалтай байна. Мөн хууль гарагыг хүлээж байна. Хэрвээ хууль батлагдвал хуулийн зохицуулалтаар явах байх. Хэрвээ хууль гарагүй бол хандивлагчдын санхүүжилтээр цааш явна гэсэн бодолтой байна. Европын банкны санхүүжилт саадгүй явж байгаа. Одоогоор бидэнд ямар нэг зарцуулалтын тайлан өгдөггүй учраас энэ талаар мэдээлэх боломжгүй юм. Улсын төсвийн санхүүжилт нь аудиторын ажлын гэрээ 186 сая төгрөгөөр хийгдсэн байгаа. Бид 200 сая төгрөгөөр төсөвлөсөн байсан бөгөөд хэмнэлттэй явж байна. Хэрвээ хэмнэлт нь зөвшөөрөгдвэл энэ мөнгөнөө Үнэлгээний хорооны гишүүдийн урамшуулах хуулийн заалттай байгаа. Мөн улсын төсвийн санхүүжилтээс хурлын урамшуулал гэж жаахан мөнгө байгаа үүнийг ажлын хэсгийн гишүүдийн хуралд оролцсон байдлаар нь хуваарилах ёстой. Иймэрхүү л байх шив дээ.

Н. Баярсайхан: Санхүүжилт зогсох нь гэдгийг ойлголоо. Төлөвлөгөөгөө хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэр баталгаатай байдал ямар юм бол гэж энэ асуултыг тавьсан юм. Гэтэл санхүүжилт ийм нөхцөлтэй байхад 2014 оны төсөв 180,0 саяар төлөвлөгдсөн байгааг ойлгохгүй байна.

Ш.Цолмон: Одоогоор иймэрхүү байна тодорхой дүгнэлт хэлэхэд эрт байна. 5 сараас наана хууль батлагдвал ямар нэг байдлаар зохицуулалт хийгээд улсын төсвөөс санхүүжих байх. Санхүүгийн эх үүсвэр хайж олох шаардлага байгаа. Бид олно гэж үзэж байгаа. Хуулийн үзэл баримтлал Сангийн яаманд явж байгаа байх. Энэ нь бүх яамдуудаар явж санал гэх мэтчилэн нилээд хугацаа шаардах байх. Амжвал 5 дугаар сараас наана өргөн барих байх.

Ш.Цолмон: 2014 оны төлөвлөгөөг яриагүй байгаа.

Б.Баярмаа: Тийм л дээ гэхдээ үүнийг 2014 оны төлөвлөгөөндөө оруулвал яасан юм бэ? гэсэн санал байна.

Ш.Цолмон: Энэ талаар төлөвлөгөөнд тусгагдаагүй байгаа. Зөрүүний талаар ажлын хэсэг Ганхуяг сайдтай ярилцсан байгаа.

Б.Батболд: Зөвлөмжийн дагуу хийх арга хэмжээний төлөвлөгөө гээд тусад нь хийгээд хэрэгжүүлмээр байна.

Ш.Цолмон: Аан за ойлголоо.

Э.Сумъяа: 2013 төлөвлөгөөнд хэдэн асуудал тусгагдсан үүнээс хэдийг нь хийгээгүй байна гэдгээ маш товчхон нэгтгээд слайдан дээр үзүүлэх хэлбэрээр бэлтгэмээр байна. Өнгөрсөн жилийн Үндэсний зөвлөлд ийм асуудлууд тавигдсан. Үүнээс биелэсэн болон биелээгүй асуудлаа товчхон бэлтгээд Ерөнхий сайдад танилцуулахад бэлдээрэй.

ШИЙДВЭРЛЭСЭН нь: ОУИТБС-ын 2013 оны төлөвлөгөөний биелэлтэд Ажлын хэсгийн гишүүдээс хуралдаан дээр гаргасан саналыг тусган Үндэсний зөвлөлд танилцуулахыг Ажлын албанад даалгав.

III. ХЭЛЭЛЦСЭН нь: Монгол Улсын ОУИТБС-ын 2014 оны ажлын төлөвлөгөө

Н.Алгаа: Талууд түрүүний ярилцсан зүйлээ тус бүрдээ хэлэлцэж тохиролцоод нэгдсэн нэг санал оруулж ирж зөвшилцөх хэрэгтэй байгаа. Амжвал нэг, хоёр дугаар сард энэ ажлаа хийх нь зүйтэй юм.

Ш.Цолмон: Бидэнд ярилцах юм маш их байгаа. Удирдамжин дээр хүртэл ярих юмнууд байгаа шүү.

Н.Баярсайхан: ТАН эвслийн хүний эрх хөгжил төвөөс мониторинг хийж байгаа. Үүнийг дараагийн ажлын хэсгийн хуралд танилцуулах гэж байгаа үр дүн нь сонирхолтой юм гарах байх. Нэг хурал дээр олон асуудал оруулж ирэхээр амжихгүй, ондоо багтаад 1-2 ажлын хэсгийн хурал болно. Тиймээс дараагийн АХ-ийн хурлын хэлэлцэх асуудалд оруульяа гэсэн хариу өгсөний дагуу хойшлуулаад байгаа.

Б.Баярмаа: Төлөвлөгөөн дээрээ оруулаад энэ асуудлуудаа хэдүүлээ хийчихмээр байна.

Л.Долгормаа: Тайланг сонсож байхад зөрүүг аль болох бага гаргах хэрэгтэй гээд байна. Манай дээр болохоор зөрүү их гараад байна гэж байлаа. Тэгэхээр ямар компаниуд дээр зөрүү их гараад байна гэдгийг тодорхой болгоод юунаас болоод энэ зөрүү гарав гэдгийг тайлбарлаж мэдээлж байх нь зүгээр юм. Бүгдээрээ зорилго зарчмын нэгдсэн нэг ойлголттой болвол хөдөө орон нутагт явахад нэгэн санаатай нэг хэл яриатай байх ба ингэснээр цаашид сурчилгаа хийхгүй байна гэдэг яриа ч байхгүй болох байх. Тайлангийн зөрүүний зөвлөмжийг хялбаршуулсан байдлаар эмхэтгээд тараах нь зүйтэй.

Б.Дэлгэрмаа: 2012 оны тайлангийн зөвлөмжийг хэвлээд тараана гэсэн үгүү. Зөрүү болон шалтгааныг тайлбарласан.

Л.Долгормаа: Тийм. Гол нь зөрүүний шалтгааныг ийм учраас энэ зөрүү үүссэн байна гэдгийг тайлбарласан байх шаардлагатай. Цаашилбал энэ чинь тухайн компани нэр төртэй холбоотой учраас цаashi өөрийн нэр сүрээ бас бодох байх гэх мэт олон талын нөлөөтэй юм.

Э.Сумъяа: Манай ажлын хэсгийн бүх гишүүдэд 2012 оны дэлгэрэнгүй тайлан очно. Мөн эцсийн тайлан гарсаны дараа тайлангийн хураангуйг мөн өгөх байх. Нэгдсэн нэг тайлбартай байна түүнээс хүн болгон нэг тоо гаргаж ирээд тэр бүхнийг тусад нь тайлбарлана гэж байхгүй. Аймаг тус бүрээр бас аймгууд руу явуулна.

Ш.Цолмон: ОҮИТБС-ын 5 дэд зорилтын хурээнд явах хэрэгтэй гэж байгаа. Үйл ажиллагаа төлөвлөөд байна гээд байгаа. Ер нь бол зорилтоо тавиад түүнд зориулан үйл ажиллагаа төлөвлөх нь зүйтэй гэж үзэж байгаа. Гишүүд төлөвлөгөөтэйгээ сайн танилцаарай. Үүнийг анхаарч үзнэ биз.

Н.Баярсайхан: Нэг санал хэлье. Одоо зорилго, зорилт гэж 2 юм гарч ирээд байгаа юм. Тэгэхээр зорилго гэдэг дээр нь 7 стандартаа тавьчихвал ясан юм бол. Бид нарын ажлын төлөвлөгөөнд стандартыг хэрэгжүүлэх гэж ороод байгаа. Тэгэхээр албан ёсны орчуулагчаар стандартаа орчуулзуулж нэгдсэн ойлголттой болох, ямар нэг орчуулгад буруу өгөх асуудал байхгүй талуудыг нэг мөр ойлголттой болгох талаар ажиллах хэрэгтэй байна. Албан ёсоор хэвлэн нийтлэх, вэб сайтад бас тавьмаар байна. Тэгээд нэгдсэн нэг нэр томъёо хэрэглэхгүй бол орон нутагт өөр өөрөөр яриад байна. Тухайлбал, Орон нутгийн эдийн засгийн оролцоо- орон нутгийн агуулга, нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид- давуу эрхтэй хувьцаа эзэмшигчид гэх мэт, нөлөөлөл гэх юм уу юу гэж нэрлэх гэх мэтчилэн. Энэ стандартыг хэрэгжүүлэхэд төрийнхөн яаж оролцох юм, ИНБ-ынхан яаж оролцох вэ, компани яаж оролцох вэ гэдгээ ярилцаж байгаад хийх ажлуудаа ярьмаар байна. Бас нэг юм нь та нарын төсвийг харахаар 6 сард дуусчих гээд байдаг. Гэтэл төлөвлөгөөг харахад одоо 189 сая төгрөгний ажил тавигдсан байна. Тэгэхээр төсөв нь хаанаас гарах гэж байгаа юм. Ийм их мөнгөтэй болох хандлага ажиглагдсан юмуу. Олно гэж бодсон юмуу?

Ш.Цолмон: Олоогүй олно л гэж бодож байна.

Н.Баярсайхан: Тэгэхээр орон нутагт 61 сая төгрөг хэвлэл мэдээлэл дээр 71 сая төгрөг төсөвлөсөн байна. Тэгэхээр зэрэг бид гол анхаарлын хүндийн төвөө хаана нь тавих юм бэ. Орон нутаг, аймгуудын оролцоог чадавхижуулахад зориулж төсвөө ахиухан тавих нь зүйтэй юм шиг. Дан ганц хэвлэл мэдээлэлд 71 сая төгрөг өгөөд бид юутай үлдэх болоо. Энэ жилийн орон нутагт зохион байгуулсан арга хэмжээнүүд, урьд жилүүдэд хийж байсан бүсчилсэн семинаруудаас харж байхад төрийнхөн түлхүү, томоохон компаниуд түлхүү оролцож байна. Аудитад ордоггүй жижиг компаниуд, иргэд, ИНБ-ынхан оролцож чадахгүй байгаа тул ирэх жил амийгуудыг бүсчилж биш аймаг тус бүр дотроо Олон талт хээлцуулгүүд зохион байгуулах нь үр дүнтэй sagandaj байна. Харин ажлын хэгийн гишүүд хуваагдаж очоод оролцдог зохион байгуулдаг хэлбэр лүү шилжих нь зүйтэй.

Орон нутагт хурал хийхээр төрийнхөн ирдэг юм байна. Томоохон компаниуд ирдэг харин жирийн иргэд ирдэггүй юм байна лээ. Цаашдаа бид орон

нутагт ард иргэдтэй ярилцах уулзах ажлыг түлхүү хийх нь зүйтэй юм шиг санагдаж байна. Төлөвлөгөөг 1 сараар 2 сараар хийе.

Э.Сумъяа-Төлөвлөгөөндөө зөвлөмж хийх хэрэгтэй байна. Талуудаас ирсэн саналыг дагуу зөвлөмжөө гаргачихна. Нөгөөдөр буюу 12 дугаар сарын 5-нд Засгийн газрын байгууллагууд уулзаж зөвшилцөөд, Баярсайхан, Алгаатай хоёр хүн аваад зөвлөмжөө яаж гаргах гэдэгээ боловсруувал яаж байна.

Б.Дэлгэрмаа: Алгаа дарга хэлэхдээ талууд өхлээд тус тусдаа саналаа бэлтгээд дараа нь нэгтгэж зөвшилцөө гэсэн.

Э.Сумъяа-Сангийн яам, татварынхан энэ дээр их чухал үүрэгтэй шүү. Ашигт малтмалын Мөнхсайхантай хамтарч болно.

Н.Баярсайхан: Бид нар 222 дугаар тогтоолын дагуу тайлангаа Их хуралд тавих ёстой шүү дээ.

Э.Сумъяа: Түүнийг яах вэ төсвийн байнгын хороонд оруулаад өгчиж болно. Хэлэлцвэл хэлэлцэнэ биз. Ерөнхий сайдад танилцуулах ёстой. Ер нь Ганхуяг сайд авчихсан байгаа. Төрийн байгууллагынхан нийлээд санал боловсруулаад Үндэсний зөвлөлийн хурлаас наана нэгтгээд ирүүлэх хэрэгтэй байна.

Б.Дэлгэрмаа: Талуудад юмаа хийх хугацаа өгөхгүй юм уу?

Ш.Цолмон: Үндэсний зөвлөлийн наана гэдэг чинь бас нэг удаагийн ажлын хэсгийн хурал байгаа. Тэрэн дээр бас зохион байгуулалтын юм хийгдэх байх. Дараагийн ажлын хэсгийн хурал дээр дэд зөвлөлийн ажиллах журам зэрэг асуудлуудыг ярилцах байгаа. Тэрэн дээр тал талаасаас саналаа цуглуулаад ярвал ямар бол.

Э.Сумъяа: Одоо оны сүүл болсон хүмүүс олдохгүй маш хэцүү шүү. Ямар ч байсан 3 талаасаа ярилцая. Тэгээд Үндэсний зөвлөлийн хуралд оруулахын наана ажлын хэсгийн хурлаар хэлэлцэе.

Н.Баярсайхан: Тэгвэл орчуулган дээрээ анхаарч, хурлын наана орчуулаад тараачихвал зүгээр байна. Тэгээд нэгдсэн нэг ойлголттой болцгооё. Ойлголтын зөрүүгээс өөр өөр юм ярьж тайлбарлах тал ажиглагдсан. Цаашид ингэж явмааргүй нэгдсэн ойлголттой болгох хэрэгтэй

Л.Долгормаа: Стандарт гэж яриад байх юм. Стандарт чинь ОУ-ын стандарт биш, ISO биш шүү дээ. Манай стандарт болгочихвол бид ингэж ярьж болно.

Ш.Цолмон: Ер нь бол шаардлага л гэж нэрлэж байгаа л даа.

Н.Баярсайхан: Олон улсад ч гэсэн стандарт уу, шаардлага уу гэдэг маргаантай л байгаан байна. Үнэхээр Монгол улсын стандарт болговол сайн л даа. Гэхдээ л ИНБ-ын ОУ-ын сүлжээгээрээ стандарт гэж ярьж байя гэж зөвлөж байгаа. Тэгэхээр түрүүний хэлсэн орчуулга дээрээ тогтоё талууд нэг мөр ойлголт нэр томъёотой болжээ гэдэг чинь энэ шүү дээ.

Ш.Цолмон: Орчуулгыг энэ долоо хоногт тараая. Ер нь орчуулагдчихсан байгаа ганц нэг нэр энэ тэр л засах байх.

Н.Баярсайхан: үүнийг олон улсад стандарт гэж хэлж байгаа. Хамгийн наад захын заавал хэрэгжүүлэх ёстой зарчмуудыг заасан байдаг.

Н.Долгормаа: Тэгвэл шаардлага л гэх ёстой.

Б.Дэлгэрмаа: Хурлын шийдвэрт аудитын зөвлөмж гэж оруулах уу.

Н.Баярсайхан: Дүгнэлт зөвлөмж гэж тусгана

Э.Сумъяа: Шилэн данс, нээлттэй эдийн засгийн түншлэл гэж Засгийн газраас хөтөлбөр хэрэгжүүлж байгаа. Энэ чинь манайтай адил бүх юмыг ил тод болгох юм. Хэдий хэмжээний зүйлийг материаллаг гэж үзэх вэ гэдэг байгаа юм.

Ш.Цолмон: 1 сая төгрөгнөөс дээш бол материаллаг гэж үзнэ.

Э.Сумъяа: 2 сая, 5 саяаас дээшхи төлбөрийг материаллаг гэж үзэх үү гэдгээ тогтох хэрэгтэй байгаа.

Б.Батболд: Мэдээлэлийн танхим байгуулах ажлыг 2014 он дээр тавьсан байгаа юу. Төлөвлөгөөн дээр байхгүй байх шиг байна.

Ш.Цолмон: Тэр ажлыг хойшлуулсан байгаа.

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. ОУИТБС-ын 2014 оны төлөвлөгөөний төсөлд Ажлын хэсгийн гишүүдээс хуралдаан дээр гаргасан саналыг тусган засч найруулан Үндэсний зөвлөлд танилцуулахыг Ажлын албанд даалгав.

2. ОУИТБС-ын Үндэсний тайланд аудитын консорциумын жил бүр өгсөн зөвлөмжийн давхардлыг судлаж, зөвлөмжийг биелүүлэх хүрээнд 2014 онд хэрэгжүүлэх боломжтой ажлын жагсаалтыг талууд бие даан хэлэлцэн зөвшилцэж, 2014 оны төлөвлөгөөний төсөлд тусгах саналыг төлөөллийн ахлагч нар 12 дугаар сарын 10-ны дотор Ажлын албанд хүргүүлэхээр харилцан тохиролцов.

Ажлын хэсгийн хурал 18 цагт 25 минутад өндөрлөв.

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:

Засгийн газрын ахлах референт

Э.Сумъяа

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга,
ажлын албаны зохицуулагч

Ш.Цолмон

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

Ажлын албаны санхүүгийн
мэргэжилтэн

А.Огтонтунгалаг